

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2020 оны 03 дугаар сарын 09-ний өдөр

№08/20

Говьсүмбэр аймаг

- 1. Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд болон байгууллага** *Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Содном*
- 2. Хэрэглэгчийн хаяг:** *Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум*
- 3. Хэрэглэгчийн байршил, зэрэглэл:** *Говьсүмбэр аймаг Шивээговь сум, III зэрэглэл*
- 4. Ажил үйлчилгээний зориулалт** *320 хүүхдийн 3-р сургуулийн барилга*
- 5. Техникийн нөхцөл олгох үндэслэл:** *Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Содномын 2020.03.03-ны өдрийн 01/238 тоот техникийн нөхцөл хүссэн албан бичиг, холбогдох бичиг баримт*
- 6. Суурилагдсан чадал:** *112 кВт*
- 7. Холбогдох цэг:**
7.1 320 хүүхдийн 3-р сургуулийн барилгын 380 В-ын цахилгаан хангамжийг Шивээговь сумын 6/0.4 кВ ТП-55 дэд өртөөний 0.4 кВ-ын ерөнхий шинээс 120 мм²-аас багагүй хөндлөн огтлолтой хос кабель шугамаар тэжээнэ.
- 8. Тоолуур хэмжих хэрэгсэл:**
8.1 Шинээр гаргаж, салбарлаж буй кабель шугамын эхэнд ачаалалд тохирсон автомат ба стандартчлал хэмжил зүйн төвөөс загварын туршилтанд орж ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан гурван фазын электрон тоолуур монтажилж угсрах.
8.2 Кабелийг газраар 0.7 м-ээс багагүй ухсан шуудуугаар эсвэл зориулалтын нүх хоолойгоор явуулах ба үзүүрүүдэд төгсгөвч, орчин үеийн шинэ технологитой муфть хийж холбох ба галын аюулгүй байдлыг хангаж угсарна.
8.3 Шинээр татаж буй шугамын төгсгөлд ачаалалд тохирсон автомат, гал хамгаалагч бүхий бүрэн тоногтой 0.4 кВ щит тавина.
- 9. Тусгай заалтууд:**
9.1 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурвас, газрын зөвшөөрлийн талаар холбогдох албан газраас нь зөвшөөрөл авна.
9.2 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.
9.3 Цахилгааны оруулга, гаргалгын кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга

байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.4 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт хэмжилтийг "БЗӨБЦТС" ТӨХК-иар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

9.5 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт, БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу цахилгаан түгээх сүлжээнд холбогдоно.

10. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Цахилгаан тоноглол болон кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар БЗӨБЦТС ТӨХК –ийн Говьсүмбэр ЦТССалбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.2 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.


10.3 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.4 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.10 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.5 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.6 Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

ТҮАХМ,ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
ХҮАХМЕНЕЖЕР



Ё.БОЛДБААТАР
Б.БАТТУУЛ